



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

"Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам" батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хорооны 2012 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЭЭГЧ
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД

Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн
238 дугаар тогтоолын хавсралт



**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ТООЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг . Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/-гийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харицааг энэ журмаар зохицуулна.

**Хоёр. Сангийн үйл ажиллагаанд тавигдах
зохистой харьцааны шалгуур үзүүлэлт**

2.1. Сан нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

2.1.1. өөрийн хөрөнгө нь 5,000,000,000.0 /таван тэрбум/ төгрөгөөс доошгүй байх ба мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн байх;

2.1.2. нэг зээлдэгч /жижиг, дунд үйлдвэр эрхлэгч/-д гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэлх хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй;

2.1.3. гаргасан зээлийн батлан даалтын нийт хэмжээ нь өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй;

2.1.4. өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг өөрийн хөрөнгийг нийт активт харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 10 хувиас доошгүй;

2.1.5. цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй;

2.1.6. Сангийн өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээгээр Засгийн газрын өрийн бичиг худалдаж авч болох ба үүнээс урт хугацаат Засгийн газрын өрийн бичигт оруулах хөрөнгө оруулалт нь нийт өрийн бичгийн 20 хувиас хэтрэхгүй;

2.1.7. үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй;

2.1.8. төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шалгуур үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулж тооцох ба зохистой харьцаа нь 5 хувиас доошгүй байх;

2.1.9. Сан нь батлан даалтын үүрэг гүйцэтгэх чадварыг хангах үүднээс нөөцийн сантай байх;

2.1.10. банк, санхүүгийн байгууллагад мөрдөж байгаа активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг мөрдөж ажиллах;

2.1.11. нөөц санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Гурав. Хороонд тайлагнах, хяналт тавих

3.1. Энэхүү журмын хавсралт 1-ийн дагуу батлан даалтын мэдээ, зээлийн батлан даалтын олголт, төлөлтийн тайлан, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгчийн батлан даалтын мэдээ, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын тайланг сар бүр гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор, энэхүү журмын хавсралт 2-ын дагуу зээлийн батлан даалтын тайлан, Сангийн яамнаас баталсан маягтын дагуу санхүүгийн тайлан гаргаж улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор тус тус Хороонд ирүүлнэ.

3.2. Сан нь зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан дотооддоо мөрдөхөөр баталсан журам, заавар, тэдгээрт өөрчлөлт орсон тухай бүр Хороонд мэдэгдэнэ.

3.3. Сангийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрт орсон өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусгаж Хороонд мэдээлнэ.

3.4. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, энэхүү журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж, шалгалт хийнэ.

3.5. Хорооны хянан шалгагч Сангаас ирүүлсэн улирлын санхүүгийн тайлан, мэдээг энэ журмын 2.1-д заасан шалгуур үзүүлэлт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянан тайлангийн хариугаар хугацаат үүрэг даалгавар болон зөвлөмжийг боловсруулан тайлант улирлын хоёр дахь сарын 05-ны өдрийн дотор багтаан Санд хүргүүлнэ.

3.6. Хорооны хянан шалгагч нь тайлант оны Сангийн санхүүгийн үзүүлэлтүүд нь өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн байдал, түүний шалтгаан, санхүү, төлбөрийн чадвар болон зохистой харьцаануудыг тооцоолон, холбогдох үзүүлэлтүүдээр динамик шинжилгээ хийн Сангийн үйл ажиллагаанд зайны хяналтын дүгнэлтийг тухайн тайлант жилийн дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор гарган удирдлагад танилцуулж хувийн хэрэгт хадгална.

3.7. Сангийн үйл ажиллагаанд эрсдэл үүсч болзошгүй гэж үзвэл Хороо дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

3.7.1. өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;


3.7.2. зээлийн батлан даалт нэмж гаргахыг зогсоох, хязгаарлах.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан
 “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны
 шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын хавсралт 1



БАТЛАН ДААЛТЫН МЭДЭЭ

... оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

| Д/д | Зээлдэгчийн нэр | Зээл олгосон байгууллага | Зээлийн хэмжээ | Зээлийн хугацаа /жилээр/ | Батлан даалтын хэмжээ | Батлан даалтын хувь | Шимтгэлийн хувь | Батлан даалтын шимтгэлийн дүн | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь |
|-----|-----------------|--------------------------|----------------|--------------------------|-----------------------|---------------------|-----------------|-------------------------------|----------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ:/овог нэр/

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ОЛГОЛТ, ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

... он ... сар ... өдөр

/төгрөгөөр/

| Д/д | Зээлдэгчийн | | | Батлан даалттай зээл | | | | Батлан даалтын | | | |
|-----|-------------|------------------------|---------------------|----------------------|----------|----------------|----------|----------------|----------------|---------------|-----------------|
| | овог нэр | харьяалал /хот, аймаг/ | олгосон байгууллага | огноо | | олгосон хэмжээ | үлдэгдэл | хувь | эхний үлдэгдэл | төлөгдсөн дүн | эцсийн үлдэгдэл |
| | | | | олгосон | төлөгдөх | | | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ:/овог нэр/

ХУГАЦАА ХЭТЭРСЭН БОЛОН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛДЭГЧИЙН БАТЛАН ДААЛТЫН МЭДЭЭ

... он ... сар ... өдөр

/төгрөгөөр/

| Д/д | Зээлдэгчийн нэр | Зээл олгосон байгууллага | Үйл ажиллагааны төрөл | Батлан даалт авсан огноо | Зээлийн хэмжээ | Батлан даалтын хэмжээ | Зээлийн үлдэгдэл | Батлан даалтын хувь | Батлан даалтын үлдэгдэл | Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл | Хугацаа хэтэрсэн батлан даалтын үлдэгдэл | Батлан даалтад эзлэх хувь | Хугацаа хэтэрсэн хоног | Зээлийн ангилал |
|-----|-----------------|--------------------------|-----------------------|--------------------------|----------------|-----------------------|------------------|---------------------|-------------------------|-----------------------------------|--|---------------------------|------------------------|-----------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| | | | | | | | | | | | | | | |

Жич: Тайлбарт зээлийн хугацаа хэтэрсэн нөхцөлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой бичнэ.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ:/овог нэр/

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН БАТЛАН ДААЛТЫН ТАЙЛАН

... он ... сар ... өдөр

/төгрөгөөр/

| Д/д | Зээлдэгчийн | | Батлан даалттай зээл | | | | | | Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэхэмжилсэн дүн | Үүрэг гүйцэтгэсэн | | | Тайлбар | |
|-----|-------------|------------------------|----------------------|---------|--------|--------------------------|---------------|---------------------------|---|-------------------|-------|----------------|---------|--------------------------------|
| | нэр | харьяалал /хот, аймаг/ | олгосон байгууллага | огноо | | олгосон дүн /төгрөгөөр / | төлөгдсөн дүн | үлдэгдэл дүн /төгрөгөөр / | | ангилал | огноо | батлан даалтын | | |
| | | | | олгосон | дуусах | | | | | | | дүн | | Нийт батлан даалтад эзлэх хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | |
| | | | | | | | | | | | | | | |

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ:/овог нэр/

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан
 “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны
 шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын хавсралт 2



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ТАЙЛАН

20...оны ... дугаар сарын ...-ны өдрийн байдлаар

/төгрөгөөр/

| Д/д | Батлан даалт хүсэгчийн нэр | Зээл олгосон байгууллага | Олгосон зээлийн хэмжээ | Зээлийн үлдэгдэл | Батлан даалтын хувь | Батлан даалтын эхний үлдэгдэл | Батлан даалтын өөрчлөлт | Батлан даалтын эцсийн үлдэгдэл |
|-----|----------------------------|--------------------------|------------------------|------------------|---------------------|-------------------------------|-------------------------|--------------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ:/овог нэр/